



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 07

Тавин

Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих, Хороо болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга Ч.Уранчимэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Г.Уранбилэг нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2002 оны 02 дугаар сарын 20 ны өдрийн  
07 дугаар тогтоолын хавсралт

Хороо:

Хорооны дарга: Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Сум хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэр хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүдэд: Ерөнхий нягтлан бодогч, санхүү албаны дарга

Ахмадын хороон дарга

ХХЭрхлэгч иргэн Ш.Анхтуяа

Хяналтын зөвлөл:

Хяналтын зөвлөлийн дарга: ИТХурал дахь МАНамын бүлгийн дарга Г.Тогтохбүрэн

Нарийн бичгийн дарга: Сум хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэр хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: Төрийн сангийн мэргэжилтэн

ХХЭрхлэгч Д.Нацаг

А.Должинсүрэн